



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/262

Хэрлэн сум

Хяналт тавих ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Нөөцийн мах нийлүүлэх, худалдан борлуулах үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнээр томилсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Н.Мөнхчимэг

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хяналтын Улсын ахлах байцаагч

Нарийн бичиг:

Г.Ариунчимэг

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд

Г.Ганжуур

Мал эмнэлгийн газрын Улсын байцаагч

О.Оюунтуяа

Стандарт, хамжил зүйн хэлтсийн Баталгаажуулалтын шинжээч

Б.Энхболор

Эрүүл мэндийн газрын Хүнсний эрүүл ахуйн хяналтын Улсын байцаагч

2. Нөөцөлсөн махны эрүүл ахуйн шаардлага, тоо хэмжээ, ангилан савлалт, хаяг шошго, үнэ, чанар аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтад хяналт тавьж 7 хоног бүр тайланг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Н. Мөнхчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\Захирамж-2023
231010864